

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 30 дугаар тэмдэглэлд:

“ХИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэх “Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн хөрөнгө оруулалтыг концессын гэрээнд заасан эргэн төлөх хуваарийн дагуу 2020-2021 оны улсын төсөвт тусган шийдвэрлэх тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Үндэсний хөгжлийн газар болон “Шинжиан шинфа” ХХК хооронд 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан “Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн концессын гэрээний хэрэгжилттэй холбогдуулан уг төсөлд зарцуулсан хөрөнгө оруулалтыг 2020-2021 оны улсын төсөвт тусган шийдвэрлэх асуудлыг нотолсон захидлыг “Шинжиан шинфа” ХХК-д хүргүүлэх тухай асуудлыг хэлэлцээд Засгийн газрын хүлээсэн төлбөрийн үүргийг нотолсон захидал (албан бичиг)-ыг тус компанид хүргүүлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд зөвшөөрөв.

2. Концессын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт тус тус даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР